



ТӨВ АЙМАГ
БАЯНЖАРГАЛАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2021 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 29

Эрдэнэ

“Авто тээврийн тэргүүний ажилтан” цол
тэмдэгээр шагнуулахаар уламжлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8, 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Зам тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 02 дугаар сарын 21-ны өдрийн А/50 “Журам, маягт загвар шинэчлэн батлах тухай” тушаалаар баталсан “Зам тээврийн салбарын албан хаагчдад шагнал олгох журам”-ын 1.1, 2.1.1, 3.1, 3.2, 3.3 дахь заалт, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сум орон нутагтаа тогтвор сууршил, үр бүтээлтэй ажиллаж хариуцсан ажил бүртээ тогтмол амжилт гарган төрийн албанд тасралтгүй 42 жил идэвхи зүтгэл, санаачлагатай ажиллаж ажил хөдөлмөрөө өндрөөр үнэлүүлж ирсэн Совд овогтой Энхбаатарыг Монгол Улсын Засгийн газрын шагнал “Авто тээврийн тэргүүний ажилтан” цол тэмдэгээр шагнуулж өгөх саналыг Зам тээврийн хөгжлийн сайд /Л.Халтар/-г уламжилсугай.

3. “Авто тээврийн тэргүүний ажилтан” цол тэмдэгээр шагнагдахаар уламжлагдаж буй С.Энхбаатарын шагналын материалыг Зам тээврийн хөгжлийн яамны салбарын шагналаар шагнагдах иргэдийн бүртгэлийн цахим системд шивж оруулах, тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Б.Туяасайхан/-д үүрэг болгосугай.



ДАРГА Г.ОЛБААТАР